



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/19

Бэрх хот

Бэрх хотын ёс зүйн дэд
хороог томилох тухай

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Монгол улсын “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3 дах заалт, 13 дугаар зүйлийн 13.2, 13.3, 13.4 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” тогтоол, Монгол улс ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоол, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бэрх хотын ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Н.Мичидмаа (Хууль, эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

Гишүүн:

Ж.Гэрэлтуяа (Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн)

С.Ган-Эрдэнэ (Соёлын ордны Архив, бичиг хэргийн ажилтан)

Ч.Бэрцэцэг (Хүүхдийн цэцэрлэгийн арга зүйч)

Н.Энхтулга (ЭМТ-ийн Мэс заслын их эмч)

С.Эрдэнэ-Очир (ЕБС-ийн Бага ангийн багш)

Нарийн бичгийн дарга:

С.Алтанзул (ОУХ-тэй ЕБ-ын

Бэрх сургуулийн сургалтын менежер)

2.Хууль тогтоомжийг чандлан сахиж хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ шударгаар гүйцэтгэхийг ёс зүйн хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Ёс зүйн дэд хорооны ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг ёс зүйн дэд хорооны дарга (Н.Мичидмаа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ

Ч.ЭНХЖАВХЛАН

-232 601 038